



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Г “Монголын хөрөнгийн бирж” ХК-д нэр бүхий Г
хувьцаат компаниудын үнэт цаасыг бүртгэлээсээ
хасахыг зөвшөөрөх тухай

Хавсралтад нэр дурьдсан компаниуд нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3, 10.1.4, 10.1.5 дахь заалтуудыг хэрэгжүүлээгүй, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэх ёстой мэдээллүүдийг хуульд заасан хугацаанд нь хүргээгүй зэрэг зөрчлүүдийг удаа дараа гаргасан, мөн түүнчлэн “Монголын хөрөнгийн бирж” ХК-иас 2013 оны 08 дугаар сарын 05–ны өдрийн 1/531 тоот албан бичгээр нэр бүхий компаниуд нь Хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шалгуур үзүүлэлт, бусад нөхцөл шаардлагыг хангаж ажиллахгүй байгаа тул өөрийн бүртгэлээс хасах шаардлагатай байгаа тухай хүсэлт ирүүлснийг тус тус ТЭМДЭГЛЭН:

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1 дэх заалт болон Улсын Их Хурлын 2013 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1 дэх заалтын 3 дахь хэсэг, Хорооны даргын 2013 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 43 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурьдсан нэр бүхий 57 /тавин долоон/ хувьцаат компанийн нийтэд санал болгон гаргасан үнэт цаасыг өөрийн бүртгэлээсээ хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д /Х.Алтай/-д зөвшөөрсүгэй.

2. Нэр бүхий 57 /тавин долоон/ хувьцаат компанийн үнэт цаасыг бүртгэлээс хассан шийдвэрээ Хороонд ирүүлж, энэ талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай.

3. “Монголын хөрөнгийн бирж” ХК бүртгэлээс хасах асуудлыг шийдвэрлэсний дараа компанийн зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх, эсхүл татан буулгах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаараа хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж, Хорооны үнэт цаасны бүртгэлээс хасуулах хүсэлтээ 2013 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг хавсралтад дурьдсан нэр бүхий хувьцаат компаниудын удирдлага, эрх бүхий этгээдүүдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны
08 дугаар сарын 14-ний өдрийн 278 дугаар
тогтоолын хавсралт

№	Компанийн оноосон нэр	Үнэт цаасны код	Гаргасан хувьцааны тоо
1	"Агро-Амгалан" ХК	12	86,302
2	"Ардын зориг" ХК	60	107,797
3	"Баянмод уул" ХК	62	87,590
4	"Бат хийц" ХК	76	93,254
5	"Баяндөхөм" ХК	83	91,469
6	"Цагаанчулуут" ХК	91	50,328
7	"Дэл баянбулаг" ХК	93	177,288
8	"Сэлэнгэ гурил тэжээл" ХК	134	787,450
9	"Ноён шанд" ХК	163	86,838
10	"Орхон" ХК	170	75,304
11	"Залуучууд" ХК	172	337,013
12	"Хангай" ХК	174	59,112
13	"Хужирт Өргөө" ХК	180	88,922
14	"Шар хоолой" ХК	183	181,683
15	"Эрдэнэтолгой төв" ХК	184	114,419
16	"Өргөн жим" ХК	189	70,000
17	"Мандал" ХК	194	72,053
18	"Зоос трейд" ХК	197	187,090
19	"Шахайт хайрхан" ХК	215	66,289
20	"Баянхонгор гео" ХК	222	139,734
21	"Сайншанд" ХК	250	63,681
22	"Увс" ХК	251	95,216
23	"Жаргалант-Төв" ХК	268	293,461
24	"Баянбулаг-Сэлэнгэ" ХК	270	51,097
25	"Мерей" ХК	272	78,187
26	"Буянтбулаг" ХК	277	154,009
27	"Сэлэнгэ Хүрд" ХК	281	50,351
28	"Иж бүрэн" ХК	283	55,637
29	"Их даац" ХК	292	79,808
30	"Тээвэр цагааннуур ХК	293	68,151
31	"Автотээвэр-27" ХК	294	62,107
32	"Автодаац" ХК	295	73,343
33	"Увс хийц" ХК	304	157,758
34	"Жоншит тээвэр" ХК	305	160,057
35	"Туруун" ХК	324	50,310
36	"Монгол эд импекс"	342	1,164,066
37	"Халх буудай" ХК	348	266,663
38	"Атар төв" ХК	350	249,228
39	"Хангайн царам" ХК	357	147,489
40	"Гүн галуут" ХК	363	187,516
41	"Ус-Архангай" ХК	368	67,841
42	"Угтаал Төв" ХК	371	242,556

43	"Тахилгат" ХК	400	243,975
44	"Шинэ-Өргөө" ХК	416	63,792
45	"Налайх Өргөө" ХК	419	211,630
46	"Баянхаан" ХК	427	100,250
47	"Жимст" ХК	442	58,563
48	"Говь шанд" ХК	443	181,267
49	"Цагааннуур" ХК	446	1,379,008
50	"Алтан үсэг" ХК	463	59,367
51	"Хүнс-Төв" ХК	472	452,206
52	"Алтандуулга" ХК	473	443,087
53	"Ундрал" ХК	474	322,317
54	"Зүүнхараа-Өргөө" ХК	475	50,096
55	"Чандгана" ХК	390	95,496
56	"Асгат" ХК	253	96,182
57	"Баянбадрах" ХК	169	143,744

-00-

